



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ**

2009 оны 10 сарын 02 өдөр

Дугаар 321

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай

Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1.2.1, Эрүүл мэндийн яамны 2009 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 13.11 заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. “Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийг нэвтрүүлэх журам”-ыг нэгдүгээр, ЭМЯ-ны дэргэдэх олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийг нэвтрүүлэх ажлын хэсэг болон орон нутгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. ЭМЯ-ны дэргэдэх олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийг нэвтрүүлэх ажлын хэсгийн даргад даалгах нь:

a/ журмыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, орон нутгийн ажлын хэсэгт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах;

b/ журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө болон олон улсын байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

c/ журмын хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 4 дүгээр улиралд Эрүүл мэндийн сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж байх.

3. Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийг нэвтрүүлэх орон нутгийн ажлын хэсгийн дарга наарт даалгах нь:

a/ олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийг нэвтрүүлэх журмыг орон нутагт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг энэ оны 3-р улиралд багтаан боловсруулах;

b/ журмын хэрэгжилтийн явц, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор ЭМЯ-ны дэргэдэх ажлын хэсэгт ирүүлж байх.


4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (С.Энхболд)-т даалгасугай.



С.ЛАМБАА

Энэ тушаалын 2 дугаар  
хавсралтыг 2012 оног 299 р  
түүсааар хүчинчж болг

8 1025



Эрүүл мэндийн сайдын 2009 оны 324 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

## Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийг нэвтрүүлэх журам

### Нэг. Нийтлэг зүйл

1.1 Бага насны хүүхдүүдийг бичил тэжээлийн дутлаас сэргийлэх, тэдний хоол тэжээл, эрүүл мэндийг сайжруулах зорилгоор 06-23 сартай хүүхэд, жирэмсэн болон хөхүүл эхчүүдэд олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл (ОНБТБ)-ийг хэрэглэх, уг үйл ажиллагааны үр дүнг хянах, мэдээлэх, мэдээлэл, сургалт сурталчилгааг зохион байгуулах тогтолцоо бүрдүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2 Эрүүл мэндийн сайдын 2008 оны 9-р сарын 190 тоот тушаалаар батлагдсан ОНБТБ-ийн зөвлөмж хэмжээ, хэрэглэх зааврыг дагаж мөрдөнө.

1.3 ЭМЯ-ны дэргэдэх ажлын хэсэг нь орон нутгын ажлын хэсгүүдийн захиалгыг үндэслэн жил бүрийн 4 дүгээр улиралд ОНБТБ-ийн нэгдсэн захиалгыг боловсруулж Эрүүл мэндийн сайдын тушаалаар батална.

1.4 ОНБТБ-ийн нэгдсэн хангалтыг эрүүл мэндийн яам зохицуулна.

1.5 ОНБТБ-ийн түгээлтийг хариуцан гүйцэтгэх эм ханганд нийлүүлэх байгууллага нь Эрүүл мэндийн яамтай хамтран ажиллах гэрээ байгуулна.

1.6 Гэрээ байгуулах эм ханганд нийлүүлэх байгууллага нь 21 аймагт өөрийн салбартай, бүтээгдэхүүний чанарыг алдагдуулахгүй хүргэх хүчин чадалтай байгууллага байна.

### Хоёр. ОНБТБ-ийг зорилтод бүлэгт түгээх

2.1 Орон нутгийн ажлын хэсэг нь тухайн орон нутгийн зорилтот бүлэгт түгээх хуваарь, ОНБТБ-ийг түгээх жирэмсний хяналтын эмч, сум, өрхийн эмчийг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын даргаар батлуулж түгээх үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

2.2 Жирэмсэн эмэгтэйчүүдэд уулгах ОНБТБ-ийг жирэмсний хяналтын эмчид хүлээлгэж өгөх ба жирэмсний хяналтын эмч эмэгтэйг жирэмсэний хяналтад анх ирснээс төрөх хүртэлх хугацаанд сар бүр бэлдмэлийг олгоно.

2.3 Төрөөд 1 сар болсон хөхүүл эхчүүдэд 6 сарын турш уух бэлдмэлийг сум, өрхийн эмч сар бүр олгоно.

2.4 Сум, өрхийн эмч хүүхдэд ОНБТБ-ийг 6, 12, 18, 23 сартайд нь 60 ширхэгээр тус тус олгоно. (Уг бэлдэмлийг 2-3 сарын хугацаанд ууж дуусгахыг зөвлөнө.)

### Гурав. ОНБТБ-ийг мэдээ, тайлан ирүүлэх

3.1 Орон нутгийн жирэмсний хяналтын эмч, сум, өрхийн эмч нар улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор түгээлтийн тайланг орон нутгийн ажлын хэсэгт хүргүүлнэ.

3.2 Орон нутгийн ажлын хэсэг нь улирал бүрийн сүүлийн сарын 30-ны дотор түгээлтийн тайланг үндэсний хэмжээнд нэвтрүүлэх ажлын хэсэгт тайлagnана.

3.3 Жирэмсний хяналтын болон сум, өрхийн эмч нар нь зорилтот бүлгийн хүн амын тоог үндэслэн ОНБТБ-ийн нэгдсэн захиалгыг хагас, бүтэн жилээр гаргаж, орон нутгийн ажлын хэсэгт хүргүүлнэ.

#### **Дөрөв. ОНБТБ-ийн талаарх мэдээлэл сургалт сурталчилгаа зохион байгуулах**

##### **4.1 Сургалт:**

4.1.1 ОНБТБ-ийг түгээх, хэрэглэх, хяналт үнэлгээ хийх сургалтын нэгдсэн хөтөлбөр, гарын авлагыг НЭМХ-ийн ХСТ, ЗГХА-ЭМГ хамтран боловсруулж, 1, 3-р улиралд ЭМЯ-ны дэргэдэх ажлын хэсгээр батлуулна.

4.1.2. ОНБТБ-ыг хэрэглэх сургалтыг бүс нутаг, аймаг орон нутагт батлагдсан төлөвлөгөөний дагуу ЗГХА-ЭМГ, НЭМХ-гийн ХСТ хамтран зохион байгуулна.

4.1.3 Орон нутгийн ажлын хэсэг ОНБТБ-ийг түгээх, хэрэглэх, хяналт үнэлгээ хийх сургалтыг шийдвэр гаргагчид, эрүүл мэндийн ажилтнууд, сайн дурын туслагч нарт зохион байгуулна.

##### **4.2 Мэдээлэл ухуулга сурталчилгаа:**

4.2.1 ОНБТБ-ийн талаархи мэдээллийг олон нийт болон зорилтот бүлэгт хүргэх үйл ажиллагааны төлөвлөгөөг ЗГХА-ЭМГ, НЭМХ-гийн ХСТ хамтран боловсруулж жил бурийн 1,3-р улиралд ЭМЯ-ны дэргэдэх ажлын хэсгээр батлуулна.

4.2.2 Мэдээллийг түгээх үйл ажиллагааг батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэхэд ЗГХА-ЭМГ, НЭМХ-гийн ХСТ хамтран мэргэжил арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангана.

4.2.3 Мэдээллийг үндэсний болон орон нутгийн мэдээллийн хэрэгсэл, хамт олны оролцоо, нийгмийн зах зээлийн бүтээгдэхүүн болон сурталчилгааны бусад сувгийг ашиглан түгээх ажлыг орон нутгийн ажлын хэсэг хариуцана.

4.2.4 ОНБТБ-ийн талаархи мэдээлэл нь туршигдсан, бодит, зөв агуулгатай, зорилтот бүлгийн хэрэгцээнд нийцсэн байна.

4.2.5 Мэдээлэл сурталчилгааны материалын загвар нь бүтээгдэхүүний нэр, гол мэдээлэл, зорилтот бүлэгт нийцсэн зураг, хэрэглэх заавар, бүтээгдэхүүний найрлага, хэрэглэх хугацаа зэргээс бүрдсэн байна.

4.2.6. Мэдээлэл сургалт сурталчилгааны эцэслэн боловсруулсан материалыг ЗГХА-ЭМГ-ийн мэдээллийн санд бүртгүүлж, сонирхсон байгууллагуудад үнэгүй түгээнэ.